Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны эхний 6 сард даатгуулагч, иргэдэд 428.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 70.1 хувийг тэтгэврийн, 14.9 хувийг эрүүл мэндийн, 7.0 хувийг ҮОМШӨ-ний, 6.2 хувийг тэтгэмжийн, 1.8 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 6 дугаар сард 144.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 259.0 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 74.2 хувийг өндөр насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 12.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны 6 дугаар сарын эцэст 12407 болж, өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 2224 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 6600 буюу 53.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 24. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.8 хувь буюу 2453 нь 15-24 насны, 38.1 хувь буюу 4721 нь 25-34 насны, 22.6 хувь буюу 2809 нь 35-44 насны, 19.5 хувь буюу 2424 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 18.9 хувь буюу 2349 нь Чингэлтэй, 16.1 хувь буюу 2003 нь Сүхбаатар, 14.1 хувь буюу 1743 нь Хан-Уул, 12.8 хувь буюу 1586 нь Баянзүрх, 12.2 хувь буюу 1516 нь Сонгинохайрхан, 12.2 хувь буюу 1515 нь Баянгол, 9.6 хувь буюу 1188 нь Налайх, 3.3 хувь буюу 412 нь Багануур, 0.8 хувь буюу 95 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2015 оны 6-р сард ажилгүй 4388 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 1517 иргэн ажилд зуучлагдан орж, 2714 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 25. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /7-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	12488	14631	12407	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	4226	6544	4197	33.8	44.7	33.8
Тусгай дунд боловсролтой	1129	1015	900	9.1	6.9	7.3
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	791	801	659	6.3	5.5	5.3
Ерөнхий боловсролтой	6272	6210	6571	50.2	42.5	53.0
Мэргэжилгүй	70	61	80	0.6	0.4	0.6

2015 оны эхний 6 сард 23702 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 24.0 хувь буюу 4587 хүнээр өсчээ.

2015 оны эхний 6 сард 4318 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.4 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 5.4 хувь нь төсөвт байгууллагад, 92.2 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 6 сард 20623 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 154 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 13.0 хувь буюу 2672 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 26. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 5 сард

	2013 он	2014 он	2015 он	$\frac{2015}{2014} \%$
Амаржсан эхийн тоо	19553	20288	20468	100.9
Амьд төрсөн хүүхэд	19698	20469	20623	100.8
Эхийн эндэгдэл	10	7	5	71.4
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	270	310	312	100.6
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.71	15.14	15.13	99.9

Нялхсын эндэгдлийн 25.9 хувь буюу 55 нь Сонгинохайрхан, 24.1 хувь буюу 51 нь Баянзүрх, 12.7 хувь буюу 27 нь Баянгол, 11.3 хувь буюу 24 нь Чингэлтэй, 10.9 хувь буюу 23 нь Сүхбаатар, 10.9 хувь буюу 23 нь Хан-Уул, 2.8 хувь буюу 6 нь Налайх, 1.4 хувь буюу 3 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 32.1 хувь буюу 100 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.01 промилээр буурчээ.

Нийслэлд 2015 оны эхний 6 сард 24343 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.8 дахин буюу 15539 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 117.99 промилээр тус тус өсчээ.

Зураг 25. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 58.2 хувийг улаан бурхан, 9.0 хувийг тэмбүү, 9.0 хувийг салхинцэцэг, 6.0 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.3 хувийг заг хүйтэн, 3.6 хувийг трихомониаз, 2.7 хувийг гар хөл амны өвчин, 1.9 хувийг цусан суулга, 1.0 хувийг вируст гепатит, 1.0 хувийг улаан эсэргэнэ, 0.5 хувийг хоолны хордлого өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 27. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 6 сард

	хэмжих нэгж	2014 он	2015 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	8804	24343	15539	2.8 дах
	10000 хүнд	70.60	188.59	117.99	
Вируст гепатит	бодит тоо	300	250	- 50	- 16.7
	10000 хүнд	2.41	1.94	- 0.47	
Менингит	бодит тоо	5	3	- 2	- 40.0
	10000 хүнд	0.04	0.02	- 0.02	
Цусан суулга	бодит тоо	484	462	- 22	- 4.5
	10000 хүнд	3.88	3.58	- 0.3	
Салхин цэцэг	бодит тоо	1537	2182	645	42.0
	10000 хүнд	12.33	16.90	4.57	
Гахай хавдар	бодит тоо	142	40	- 102	- 3.6 дах
	10000 хүнд	1.14	0.31	- 0.83	
Сальмонеллөз	бодит тоо	17	31	14	1.8 дах
	10000 хүнд	0.14	0.24	0.1	
Улаан эсэргэнэ	бодит тоо	118	241	123	2.0 дах
	10000 хүнд	0.95	1.87	0.92	
Улаан бурхан	бодит тоо	-	14157	14157	-
	10000 хүнд	-	109.68	109.68	
Хоолны хордлого	бодит тоо	66	111	45	1.7 дах
	10000 хүнд	0.53	0.86	0.33	
Ёлом	бодит тоо	36	43	7	19.4
	10000 хүнд	0.29	0.33	0.04	
Бруцеллөз	бодит тоо	8	9	1	12.5
	10000 хүнд	0.06	0.07	0.01	
Нярайн халдвар	бодит тоо	3	3	-	-
	10000 хүнд	0.02	0.02	-	
Гар хөл амны өвчин	бодит тоо	819	648	- 171	- 20.9
	10000 хүнд	6.57	5.02	- 1.55	
Тэмбүү	бодит тоо	1868	2189	321	17.2
	10000 хүнд	14.98	16.96	1.98	
Заг хүйтэн	бодит тоо	707	1042	335	47.4
	10000 хүнд	5.67	8.07	2.4	
Трихомониаз	бодит тоо	841	873	32	3.8
	10000 хүнд	6.74	6.76	0.02	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	1451	1464	13	0.9
	10000 хүнд	11.64	11.34	- 0.3	
ДОХ	бодит тоо	22	7	- 15	- 3.1 дах
	10000 хүнд	0.18	0.07	- 0.11	




НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний хагас жилд Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 4.4 мянга орчим км урттай, 139 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Зураг 26. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 27. Зорчигч тээврийн чиглэлийн урт



Улаанбаатар хотын хэмжээнд 2015 оны эхний хагас жилд нийтийн тээврийн үйлчилгээг 56 аж ахуйн нэгж эрхэлсэн нь өмнөх оны мөн үеэс 9 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, их багтаамжийн автобус бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо 9.5 хувиар, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн тоо 26.1 хувиар буурчээ. Гэсэн хэдий ч зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 28. Зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй ААН-ийн тоо




Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2015 оны эхний хагас жилд 481.1 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 141.5 сая хүн тээвэрлэж, 54.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс зорчигчийн тоо 2.6 хувиар буюу 3.8 мянган хүнээр, үйлчилгээний орлого 0.2 хувиар буюу 0.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 28. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2015 оны эхний хагас жилд


Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Тээврийн хэрэгсэл (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Үүнээс:		Зорчигч (сая хүн)	Үүнээс:	
				зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор		зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	298	17.2	9.1	8.1	45.3	25.1	20.2
Автобус (хувийн)	19	876	35.8	12.5	23.3	91.7	33.4	58.3
Троллейбус (хувийн)	1	8	0.3	0.1	0.2	0.9	0.4	0.5
Бага, дунд багтаамжийн автобус	20	324	1.4	1.4	0.02	3.6	3.5	0.1
Дүн	41	1506	54.7	23.1	31.6	141.5	62.4	79.1

2015 оны эхний хагас жилд бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 42.2 хувийг шугамын орлого, 57.8 хувийг “нөхөн олговор”-ын орлого эзэлж байна. Нийтийн тээврээр зорчигчдын 44.1 хувь нь зорчих тасалбар худалдан авч үйлчлүүлсэн байхад 55.9 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хэрэгслээр 2015 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 79.1 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 31.6 тэрбум төгрөгийг нөхөн олговор хэлбэрээр тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Зураг 29. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 30. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Хүснэгт 29. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2014 оны эхний хагас жил	2015 оны эхний хагас жил
Бүгд		2526	2036
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	250	250
	Хувийн өмч	868	876
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	298	138
	Буухиа чиглэл	358	186
Троллейбус	Төрийн	57	48
	Хувийн	15	8
Такси		680	530


2015 оны эхний хагас жилд нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 2036 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 15.9 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 55.3 хувь нь их багтаамжийн автобус, 26.0 хувь нь такси байна.

2015 оны эхний хагас жилд нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 10 автобус, мөн тооны троллейбус үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй


болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 231 тээврийн хэрэгсэл (бага багтаамжийн 49 автобус, 14 троллейбус, 168 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

2015 оны эхний хагас жилд өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 755 автобус, 28 троллейбус, бага багтаамжийн 312 автобус, 420 такси, хот орчмын чиглэлд 60 гаруй тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ. Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 82.9 хувийг хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл эзэлж байв.

Зураг 31. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Зураг 32. Хүлээлтийн хугацаа, минут




Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн давхцалыг арилгах арга хэмжээ авагдаж байгаа бөгөөд ихэвчлэн туслах болон буухиа чиглэлийн тоо багасч, эдгээр чиглэлүүдэд ажиллах тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үеэс 29.7-31.2 хувиар буурсан байна. Энэ нь зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацаанд сөрөг нөлөө үзүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан тээврийнх 10 хувиар, их, дунд багтаамжийн автобусных 2 дахин нэмэгдэж, зөвхөн их багтаамжийн автобусных 0.9 хувиар буурсан байна. 2015 оны эхний хагас жилд нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 897 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 93.8 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

Зураг 33. НТ-ийн үйлчилгээний талаарх санал, гомдол, жил бүрийн эхний 6 сард



Зураг 34. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын барагдуулалт





ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2015 оны эхний хагас жилд 346.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.8 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар өсчээ.

Хүснэгт 30. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2014 оны эхний 6 сар	2015 оны эхний 6 сар
Нийт орлого	сая төг	337646.9	346456.2
Үүнээс: хүн амаас	сая төг	251001.3	267297.1
Суурин телефон цэг	тоо	163353	215696
Үүнээс: айл өрхийн	тоо	134515	180746
Утасгүй телефон	тоо	576	607
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	1928.8	1831.7
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	252822	303159

Нийт орлогын 77.2 хувь буюу 267.3 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

2015 оны эхний хагас жилд нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 215.7 мянга болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.0 хувиар нэмэгджээ.

Нийт суурин телефон цэгийн 180.7 мянга буюу 83.8 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 34.4 хувиар өссөн нь гурвалсан

үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэлд өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Зураг 35. Суурин телефон цэгийн тоо



Зураг 36. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2015 оны эхний хагас жилд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.4 сая хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 53.6 хувь буюу 1.8 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 97.1 мянгаар буурсан байна.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 315.9 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1515.8 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.6 мянга болж буурсан

нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх техникийн зохицуулалт хийгдэж ирсэнтэй холбоотой. Нийслэлд 0.8 мянган хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 37. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



2015 оны эхний хагас жилд кабелийн телевизийн үйлчилгээг 18 аж ахуйн нэгж нийслэлийн 303.2 мянган хэрэглэгчдэд хүргэжээ.

Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.7 хувийг айл өрх эзэлж байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж,

хоногт дундажаар 50-110 гаруй сувгаар үйлчилгээ хүргэсэн байна. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн хэрэглэгчдийн хувьд 49-63 хүртэл сувгаар кабелийн телевизийн үйлчилгээг хүлээн авч байна.

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-100.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-11000 төгрөгийн тарифтай байв.



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2015 оны 6-р сард дундажаар 16.7°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.3°C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 1.0°C-аар тус тус дулаан байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 31.1°C, үнэмлэхүй бага температур 3.0°C, хур тунадасны нийлбэр 9.2 мм, салхины үнэмлэхүй их хурд 19 м/секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 тохиолдлыг бүртгэжээ.


Хүснэгт 31. Агаарын бохирдолт, мг/м³

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.020	277	0.023	9	0.008
Азотын давхар исэл	NO ₂	0.040	254	0.066	30	0.024
Тоосжилт	PM ₁₀	0.100	226	0.614	86	0.095
	PM _{2.5}	0.050	172	0.134	11	0.026
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	687	4.588	-	0.530
Озон	O ₃	0.100	594	0.119	-	0.049


*- Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2015 оны 6-р сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн зам орчимд 22 удаа, 13-р хороолол орчимд 6 удаа, 1-р хороолол болон Телевиз орчимд тус бүр 1 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Амгалан орчимд 5 удаа, Телевиз орчимд 2 удаа, Баруун дөрвөн зам болон Хархорин зах орчимд тус бүр 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.


Зураг 38. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³



Зураг 39. Азотын давхар ислийн агууламж, мг/м³




Зураг 40. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³



10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Нисэх орчимд 21 удаа, Толгойт орчимд 16 удаа, Телевиз орчимд 14 удаа, Амгалан болон Хархорин орчимд тус бүр 10 удаа, 32-ын тойрог орчимд 7 удаа, 13-р хороолол орчимд 5 удаа, Баруун дөрвөн зам орчимд 3 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 5 удаа, Баруун дөрвөн зам орчимд 3 удаа, Нисэх орчимд 2 удаа, Толгойт орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 41. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³



Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, амоны азот 30.1 дахин, нитридийн нэгдэл 4.8 дахин, эрдэс фосфор 4.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.1 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 32. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 6-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Зайсан” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	9.76	хэвийн	4.65	онцгой их бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	2.16		3.18	1.1 дахин
Нитридийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.004		0.096	4.8 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.03		15.05	30.1 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.012		0.422	4.2 дахин

*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 33. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 6-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.012	0.005	0.008	0.005	0.002	0.006	-	0.009	0.003	0.009	0.016
	Хамгийн их	-	0.021	0.011	0.018	0.011	0.006	0.023	-	0.015	0.011	0.023	0.023
	XXX*-с давсан хувь	-	3	-	-	-	-	4	-	-	-	7	18
	Хэмжилтийн тоо	-	29	29	30	23	29	28	-	30	29	23	27
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.050	0.020	0.039	0.030	0.020	-	0.015	0.009	0.010	0.025	0.020
	Хамгийн их	-	0.066	0.044	0.047	0.038	0.036	-	0.021	0.026	0.022	0.041	0.030
	XXX*-с давсан хувь	-	76	3	32	-	-	-	-	-	-	3	-
	Хэмжилтийн тоо	-	29	29	19	22	30	-	10	30	29	29	27
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	0.692	-	0.485	1.803	-	0.327	0.209	0.218	0.201	0.407	0.424
	Хамгийн их	-	1.438	-	0.913	4.588	-	0.525	0.350	0.370	0.388	0.776	0.653
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	89	-	91	75	-	89	35	77	79	79	73
Тоос PM10	Дундаж	0.044	0.077	-	0.075	0.089	-	0.104	-	0.151	0.124	0.106	0.088
	Хамгийн их	0.066	0.198	-	0.208	0.289	-	0.265	-	0.614	0.431	0.264	0.162
	XXX*-с давсан хувь	-	11	-	17	30	-	53	-	72	55	48	37
	Хэмжилтийн тоо	12	28	-	30	23	-	19	-	29	29	29	27
Тоос PM2.5	Дундаж	-	0.027	-	0.029	-	-	-	-	0.031	0.025	0.022	0.019
	Хамгийн их	-	0.061	-	0.086	-	-	-	-	0.134	0.073	0.042	0.027
	XXX*-с давсан хувь	-	11	-	17	-	-	-	-	6	3	-	-
	Хэмжилтийн тоо	-	28	-	30	-	-	-	-	29	29	29	27
Озон O ₃ **	Дундаж	0.039	-	-	0.036	0.035	-	-	0.048	0.069	0.024	0.074	0.064
	Хамгийн их	0.078	-	-	0.078	0.075	-	-	0.081	0.095	0.045	0.114	0.119
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	82	-	-	91	78	-	-	35	73	79	77	79

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дундажаар тооцсон

Байгаль орчны зөрчил. Нийслэлд 2015 оны эхний 6 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 412 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 32.5 хувийг геодези зурагзүй, кадастрын зөрчил, 30.8 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 20.6 хувийг газрын зөрчил, 4.6 хувийг ойн зөрчил, 3.2 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 2.9 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 2.4 хувийг ангийн зөрчил, 1.7 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 1.3 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 58.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 1.9 сая, ангийн зөрчлөөс 30.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр, ойн зөрчил гаргасан иргэдээс 14.1 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 34. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2014 оны эхний 6 сард			2015 оны эхний 6 сард		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	26	9	5.4	5	19	5.8
Ан, амьтан	3	2	-	5	10	1.3
Газрын	15	7	0.7	9	85	18.2
Ус	3	1	3.6	3	1	-
Ургамал, хөрсний бохирдол	1	1	-	4	7	0.4
Агаар, химийн хорт бодис	13	2	1.1	18	127	1.9
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	13	6	7.4	13	13	5.0
Геодези зураг зүй, кадастр	13	6	0.6	5	134	9.5
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	1	4.8	5	12	15.4
Бусад	11	13	3.5	8	4	1.3
Бүгд	99	48	27.1	75	412	58.8



ХОТ ТОХИЖИЛТ

2015 оны эхний хагас жилд нийслэл хотыг тохижуулах ажилд 14.0 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Тохижилтын ажлаар 22 объект тохижуулснаас 2 объектыг иж бүрэн тохижуулж, 20 объектод бичил тохижилт хийжээ.

Хотын нийтийн эзэмшилд шинээр 13.1 км урт явган хүний зам, шинээр 16 хүүхдийн тоглоомын талбайг байгуулсан байна. Нийтийн эзэмшлийн зам талбайд 50 ширхэг хогийн сав, 32 сандал, 21 сүүдрэвч, 12 усан оргилуур, 6480 метр хайс хамгаалалт шинээр, 3668.7 метр урт хайс хамгаалалт, 31 хогийн сав, 42 сандал, 17 усалгааны систем засварлаж 1.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 1.9 км, орон сууцны хороололд 5.4 км, гэр хороолол орчимд 25.4 км урт гэрэлтүүлэг хийж 0.8 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд гэрэлтүүлгийн асалт дунджаар 94.7 хувь, хот нийтийн реклам асалт 93.1 хувьтай байлаа.

Хүснэгт 35. Цэцэрлэгжилтийн зарим үзүүлэлт

үзүүлэлт	Хэмжих нэгж	Бүгд	Хотын нийтийн эзэмшилд	Орон сууцны хороололд	Албан газрын орчинд	Парк цэцэрлэгт
Нэг наст ургамал	мян.ш	31.6	23.9	2.9	4.7	0.1
Цэцэрлэгжүүлсэн талбай	мян.м ²	2.7	1.2	1.2	0.3	-
Зүлэгжүүлсэн талбай	мян.м ²	165.3	147.4	14.7	3.2	-
Цэцгийн мандал	мян.м ²	6.6	5.5	0.5	0.5	0.1
Шинээр тарьсан мод	мян.ш	119.9	43.0	9.5	51.5	15.9
Шинээр тарьсан сөөг	мян.ш	201.2	176.9	9.9	7.8	6.6

Тохижилтын ажлаар 31603 ширхэг нэг наст ургамал, 2.7 мянган м² талбайд цэцэрлэгжүүлэлт, 165.3 мянган м² талбайд зүлэгжүүлэлт, 6.6 мянган м² талбайд цэцгийн мандал шинээр байгуулж, үүнд 165.1 сая төгрөгийг зарцуулав. Мөн 6.3 мянган м² талбайд нөхөн цэцэрлэгжүүлэлт, 79.5 мянган м² талбайд нөхөн зүлэгжүүлэлт хийж, 469.6 мянган м² зүлэгжсэн талбайг арчилж тордон 228.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийтийн эзэмшлийн талбайд 119878 ширхэг мод, 201197 ширхэг сөөг шинээр тарьж, 27536 ширхэг мод, 26451 ширхэг сөөгийг арчилж тордон 0.6 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэжээ.

Хог цэвэрлэгээний ажлаар 17824.3 мянган м² зам талбайг цэвэрлэж, 364.8 мянган тонн хог тээвэрлэж, Нарангийн энгэр, Морин даваа, Цагаан даваанд төвлөрсөн цэгт 393.6 мянган тонн хогийг дарж устгав. Дарж устгасан хогны 16.3 хувийг орон сууцны хороолол, 40.8 хувийг гэр хороолол, 34.3 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 8.6 хувийг зам талбайн хог эзэлж байна.

Дүүргүүдийн тохижилт үйлчилгээний байгууллагууд 2015 эхний хагас жилд 30450 золбин нохойг устгаж энэ ажилд 197.2 сая төгрөг зарцуулав.

Хүснэгт 36. Тээвэрлэсэн хог, мян.тонн, дүүргээр

Дүүрэг, бусад байгууллагууд	Тээвэрлэсэн хог	хог, бүтцээр					
		Орон сууц	Гэр хороолол	Албан байгууллага	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	4.0	1.4	1.9	0.4	0.2	0.1	-
Багахангай	4.3	2.2	2.0	0.1	-	-	-
Баянгол	54.8	24.5	13.9	11.2	5.2	-	-
Баянзүрх	64.9	14.3	20.0	16.4	14.1	0.1	-
Налайх	38.5	7.3	25.2	3.1	1.7	1.2	-
Сонгинохайрхан	69.3	10.3	36.2	16.9	5.4	0.5	-
Сүхбаатар	36.1	10.1	10.9	12.7	1.1	-	1.3
Хан-Уул	38.1	7.1	10.5	17.8	2.6	0.1	-
Чингэлтэй	54.8	13.1	23.5	10.4	7.8	-	-
Дүн	364.8	90.3	144.1	89.0	38.1	2.0	1.3



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2015 оны эхний 6 сард 17.2 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 5.9 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 37. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он VI сар	2015 он VI сар	$\frac{2015}{2014}$ %
Шахсан ус	мян.м ³	27630.9	26554.9	96.1
Борлуулсан ус	мян.м ³	23000.4	23119.1	100.5
Хүн амд	мян.м ³	16955.4	17244.7	101.7
ААНБ-д	мян.м ³	6045.0	5874.4	97.2
Татан зайлуулсан бохир	мян.м ³	22445.7	22616.6	100.8
Хүн амаас	мян.м ³	15781.2	16005.5	101.4
ААНБ-аас	мян.м ³	6664.5	6611.1	99.2
Ус борлуулалтын орлого	сая төг	8197.1	13524.4	165.0
Хүн амаас	сая төг	4781.0	7922.3	165.7
ААНБ-аас	сая төг	3416.1	5602.1	164.0
Сувагжуулалтын орлого	сая төг	4560.5	8149.9	178.7
Хүн амаас	сая төг	2324.0	3559.7	153.2
ААНБ-аас	сая төг	2236.5	4590.2	205.2

Нийт борлуулсан усны 73.8 хувийг хүн амд борлуулсан ус, 26.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.


Хүн амд түгээсэн цэвэр усны 96.2 хувь буюу 16.6 сая.м³ усыг төвлөрсөн шугамаар, 643.4 мян.м³ усыг ус түгээх байраар, 5.8 мян.м³ усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 27.2 сая.м³ бохир цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 22.6 сая.м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 42. Борлуулсан ус, сараар, мян.м³



Зураг 43. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м³



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2015 оны эхний 6 сард нийт 197 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар буурсан байна. Нийт гамшиг ослын 195 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол, харин 2 тохиолдол нь хүчтэй салхи шуурга болон гахайн мялзан өвчин байв. Хүний үйл ажиллагаатай холбоотой сум галт хэрэгслийн осол 1, химийн бодисын осол 13, бичил уурхай, нурангины осол 2, усны осол 4, үйлдвэрийн осол 1, бусад осол 174 гарсан байна. Ослоос 136 хүнийг аварч, ослын үршгийг арилгах ажилд нийт 2.0 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 38. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2014 он	2015 он	<u>2015 он</u> <u>2014 он</u>
Бүгд	1518	1793	118.1
Багануур	19	32	168.4
Багахангай	3	5	166.7
Баянгол	230	219	95.2
Баянзүрх	359	450	125.3
Налайх	57	48	84.2
Сонгинохайрхан	286	388	135.7
Сүхбаатар	232	248	106.9
Хан-уул	153	161	105.2
Чингэлтэй	179	242	135.2


Нийслэл хотод 2015 оны эхний 6 сард ой хээрийн 20 түймэр, ахуйн 1793 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар нэмэгдсэн байна.

Гал түймрийн улмаас 14 хүн (үүнээс, хүүхэд 3) амь насаа алдаж, 11 хүн (үүнээс, хүүхэд 3) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 329 хүн, 619 байшин барилга, 4.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.


Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 302, санамсаргүй байдлаас 1313, шалтгаан тогтоогдоогүй 149, бусад шалтгаанаар 29 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт 543 гэр, орон сууц, 53 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 77 машин техник, бусад төрлийн 1120 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1143, төрийн өмчийн 554, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 95, гадаадын хөрөнгө оруулалттай 1 объект өртөж, нийт 10.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 44. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 45. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2015 оны эхний 6 сард 9090 айл өрх, 5387 объектод үзлэг шалгалт хийж, 25211 галын зөрчил илрүүлж, 125 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1512 заавал биелүүлэх албан шаардлага, 1609 мэдэгдэл хүргүүлж, 34.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 6 сард 9633 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.0 хувь буюу 1180 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 54.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр доогуур байна.

Зураг 46. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 3382 хүн гэмтэж осолдож, 235 хүн нас барж, төр ард иргэдэд 59.2 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 19.5 хувь буюу 11.6 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.1 хувийг хулгайн, 25.0 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.4 хувийг залилан, 6.8 хувийг танхайн, 6.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2015 оны 6-р сарын танилцуулга

Хүснэгт 39. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 6 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	52	55	3	5.8
Хүчин	76	61	- 15	- 19.7
Дээрэм	338	252	- 86	- 25.4
Хулгай	2540	3189	649	25.6
Булаалт	101	113	12	11.9
Залилан	670	902	232	34.6
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	2396	2406	10	0.4
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	480	597	117	24.4
Бусдыг амиа хорлоход хүргэх	137	124	- 13	- 9.5
Ашиглах	94	92	- 2	- 2.1
Танхайрах	721	653	- 68	- 9.4
Бусад	848	1189	341	40.2
БҮГД	8453	9633	1180	14.0

2015 оны эхний 6 сард 28377 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.6 хувь буюу 6080 хүнээр буурсан байна.

Хүснэгт 40. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 6 сард

Дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Багануур	120	159	39	32.5
Багахангай	10	13	3	30.0
Баянгол	1376	1544	168	12.2
Баянзүрх	2019	2356	337	16.7
Налайх	172	230	58	33.7
Сонгинохайрхан	1537	1638	101	6.6
Сүхбаатар	1255	1668	413	32.9
Чингэлтэй	1202	1291	89	7.4
Хан-Уул	762	734	- 28	- 3.7
ДҮН	8453	9633	1180	14.0

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2015 оны 6-р сарын танилцуулга

Хүснэгт 41. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2015 оны эхний 6 сард

дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	40	23	57.5
Багахангай	1	0	0.0
Баянгол	594	394	66.3
Баянзүрх	1497	766	51.2
Налайх	65	42	64.6
Сонгинохайрхан	995	487	48.9
Сүхбаатар	1079	594	55.1
Чингэлтэй	832	446	53.6
Хан-Уул	311	207	66.6
ДҮН	5414	2959	54.7

Хүснэгт 42. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 6 сард


дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Багануур	19	34	17	25
Багахангай	3	2	2	1
Баянгол	382	351	301	282
Баянзүрх	685	869	600	749
Налайх	26	56	20	46
Сонгинохайрхан	495	640	448	589
Сүхбаатар	377	640	275	470
Чингэлтэй	343	415	300	345
Хан-Уул	210	182	176	170
ДҮН	2540	3189	2139	2677

2015 оны эхний 6 сард онц хүнд хэрэг 155, хүнд хэрэг 584 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9.4-14.0 хувиар буурч, харин хүндэвтэр хэрэг 4276, хөнгөн хэрэг 4618 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.5-18.4 хувиар өсчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 7100 болж, 2014 оны мөн үеэс 10.1 хувь буюу 650 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 12.7 хувь буюу 904 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 16.0 хувь буюу 1137 нь согтуугаар үйлдсэн, 4.7 хувь буюу 335 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.8 хувь буюу 343 нь хүүхэд, 18.3 хувь буюу 1299 нь эмэгтэйчүүд байна.

Зураг 47. Гэмт хэргийн тоо, ангиллаар




НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР



<http://ubstat.mn>



Статистикийн ном, эмхэтгэл,
танилцуулга, сэтгүүлийг энэхүү
апп-ыг ашиглан унших боломжтой



www.1212.mn -ээс статистик мэдээллийг
интерактив байдлаар аваарай